



ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 284

Баян-Өндөр сум

Биеийн тамир, спортын ажил үйлчилгээг
төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр
гүйцэтгүүлэх журам батлах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Захиргааны өрөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.2, 53 дугаар зүйлийн 53.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь заалт, “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр 340 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Биеийн тамир, спортын ажил үйлчилгээг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Спорт сургалтын албаны ахлах мэргэжилтэн (Э.Лхамсүрэнбаатар), Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн албаны ахлах мэргэжилтэн (Д.Одгэрэл), Санхүү, аж ахуйн албаны нягтлан бодогч (Ж.Нямжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн (М.Ариун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР

TT05956 3041893

Биеийн тамир, спортын газрын даргын
20... оны 06 дугаар сарын 09.-ны өдрийн
М/84 дугаар тушаалын хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨРИЙН
БУС БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖЭЭР
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

1.1. Энэхүү журмын зорилго нь биеийн тамир, спортын ажил үйлчилгээг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж хамтран ажиллах гэрээ байгуулах, дүгнэх,шилдэг байгууллагыг шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Биеийн тамир, спортын ажил үйлчилгээг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж гэрээ байгуулах, дүгнэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3. Төрийн бус байгууллага гэдэгт улсын бүртгэлд бүртгэлтэй биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гишүүнчлэлтэй болон гишүүнчлэлгүй ашгийн бус байгууллага байна.

1.4. Аж ахуйн нэгж гэдэгт үндсэн болон туслах үйл ажиллагааны чиглэл нь биеийн тамир спортын салбарт үйл ажиллагаа явуулах зорилготой тэмцээн, уралдаан, өдөрлөг зохион байгуулах хөрөнгө санхүү, хүний нөөцтөй компани, нөхөрлөл байна.

Хоёр.БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ:

2.1. Биеийн тамир, спортын газар нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

1. Биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу батлагдсан төсөвт багтаан спортын холбоо, клубуудтэй хамтран ажиллах гэрээ байгуулах замаар ажил үйлчилгээг гүйцэтгүүлнэ.

2. Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын дагуу тухайн төрлийн албаны хүмүүс, дасгалжуулагч, тамирчдыг тэмцээн уралдаанд оролцох боломжоор хангаж, хамтран ажиллах гэрээ байгуулсан төрийн бус байгууллагын тодорхойлолт, удирдамж, мэдүүлгийг үндэслэн чөлөөний хуудас олгоно.

3. Хууль тогтоомж болон бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээтэй нийцсэн, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ.

4. Төрийн бус байгууллагад үзүүлэх дэмжлэг нь биеийн тамир спортыг хөгжүүлэхэд чиглэгдсэн тэмцээн уралдаан зохион байгуулах болон оролцох, хэрэглэл материалы нэмэгдүүлэх, заал, зам талбай, орчин нөхцлийг сайжруулах, туршилага солилцох, багш дасгалжуулагч ажиллуулах гэсэн олон талт үйл ажиллагаа байна.

4. Энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу гэрээг дүгнэж бүрэн хангалттай, үнэлгээ авсан спорт холбоодыг шагналд тодорхойлох, хангалтгүй үнэлгээ авсан спорт холбоодтой хамтран ажиллах гэрээг цуцлах эрхтэй.

2.2. Биеийн тамир, спортын газар нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

1. Гэрээ байгуулсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана.
2. Тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд медаль авсан тамирчдад аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан мөнгөн урамшуулалт олгуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр уламжилна.
3. Улс болон бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах талаар улс, орон нутгийн төсөвт тусгуулах талаар санал хүргүүлнэ.

Гурав. БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОЛБООД КЛУБУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ:

3.1. Спортын холбоо, клубууд нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

1. Хамтран ажиллах гэрээний дагуу тэмцээн уралдаан зохион байгуулах болон оролцоход хөрөнгө санхүүгийн дэмжлэг хүсэх эрхтэй.
2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу албаны хүмүүс, дасгалжуулагч, тамирчдыг тэмцээн уралдаанд оролцуулахдаа байгууллагын тодорхойлолт гаргаж чөлөөлүүлэх бичиг авах эрхтэй.
3. Спортын төрөл, чиглэлийг хөгжүүлэх талаар биеийн тамир, спортын газартай хамтран ажиллах гэрээ байгуулах эрхтэй.

3.2. Спортын холбоо, клубууд нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

1. Тухайн жилд зохион байгуулагдах тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд хуваарийн дагуу оролцох;
2. Хамтран ажиллах гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж төлөвлөгөө, тайлан, статистик мэдээ зэргийг тухай бүр ирүүлэх;
3. Тамирчдын залгамж халааг бэлтгэж, өсвөрийн шигшээ баг бүрдүүлэх;
4. Тухайн биеийн тамир, спортын төрлийн материаллаг баазыг нэмэгдүүлэх, секц дугуйлан хичээллүүлэх, тамирчдаас сорил авах дүгнэх, бэлтгэл сургууилалтыг зохион байгуулах, хяналт тавих, ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах;
5. Тухайн биеийн тамир, спортын төрлөөр өсвөр үе, залуучууд, ахмад үеийн хамтын ажиллагааг сайжруулах, нийгэмд зэрэг хандлага бий болгох чиглэлээр бусад иргэн, байгууллагатай хамтран ажиллах;

Дөрөв. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ:

- 4.1. Биеийн тамир, спортын газар нь энэхүү журамд заасан нөхцөл шаардлагыг биелүүлсэн биеийн тамир, спортын чиглэлийн төрийн бус байгууллагатай 1 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулна. Гэрээ нь 3 хувь байна.
- 4.2. Хамтран ажиллах гэрээ нь Монгол улсын хууль тогтоомжид үндэслэсэн 2 талын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлсон байна.

Тав. ГЭРЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- 5.1. Спортын чиглэлийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний шалгуур үзүүлэлт:

| No | Шалгуур үзүүлэлт | Оноо |
|----|---|------|
| 1 | Олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан эсэх | 15 |

| | | |
|----|---|-----|
| 2. | Олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон амжилт | 15 |
| 3. | Өсвөрийн шигшээ баг бүрдүүлсэн бол 5 оноогоор, улсын аварга шалгаруулах тэмцээний амжилтыг 5 хүртэл оноогоор | 10 |
| 4. | Сар бүр статистик мэдээ ирүүлсэн эсэх | 10 |
| 5. | Биеийн тамир, спортын газраас санаачилсан ажилд оролцсон оролцоо Нээлттэй хаалганы өдөрлөг, Хүүхдийн баяр, Мод тарих, Тамирчдын баяр гэх мэт. | 5 |
| 6. | Төрийн бус байгууллагаас нийгэмд зөв үлгэр дууриалал үзүүлсэн арга хэмжээ | 5 |
| 7. | Санхүүгийн баримт тайланг бүрэн хугацаандaa тайлagnasан байдал | 20 |
| 8. | Тухайн оны гэрээгээр гүйцэтгүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл, тайлagnal | 20 |
| | Нийт оноо | 100 |

5.2. Нийтийн биеийн тамирын чиглэлийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний шалгуур үзүүлэлт:

| № | Шалгуур үзүүлэлт | Оноо |
|----|---|------|
| 1. | Зохион байгуулсан өдөрлөг уралдааны тоо | 15 |
| 2. | Зохион байгуулсан өдөрлөг уралдаанд хамруулсан иргэдийн тоо | 15 |
| 3. | Тухайн жилд хичээллэсэн иргэдийн тоо | 10 |
| 4. | Сар бүр статистик мэдээ ирүүлсэн эсэх | 10 |
| 5. | Биеийн тамир, спортын газраас санаачилсан ажилд оролцсон оролцоо Нээлттэй хаалганы өдөрлөг, Хүүхдийн баяр, Мод тарих, Тамирчдын баяр гэх мэт. | 5 |
| 6. | Төрийн бус байгууллагаас нийгэмд зөв үлгэр дууриалал үзүүлсэн арга хэмжээ | 5 |
| 7. | Санхүүгийн баримт тайланг бүрэн хугацаандaa тайлagnasан байдал | 20 |
| 8. | Тухайн оны гэрээгээр гүйцэтгүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл, тайлagnal | 20 |
| | Нийт оноо | 100 |

5.3. Фитнесс, спиннинг клубуудтэй хамтран ажиллах гэрээний шалгуур үзүүлэлт:

| № | Шалгуур үзүүлэлт | Оноо |
|----|---|------|
| 1. | Байр танхим, тоног төхөөрөмж нь стандарт шаардлагыг хангасан эсэх | 10 |
| 2. | Мэргэжлийн биеийн тамирын арга зүйчтэй эсэх | 10 |
| 3. | Тухайн жилд хичээллэсэн иргэдийн тоо | 15 |
| 4. | Сар бүр статистик мэдээ ирүүлсэн эсэх | 15 |

| | | |
|-----------|--|-----|
| 5. | Биеийн тамир, спортын газраас санаачилсан ажилд оролцсон оролцоо Нээлттэй хаалганы өдөрлөг, Хүүхдийн баяр, Мод тарих, Тамирчдын баяр гэх мэт | 5 |
| 6. | Клубээс нийгэмд зөв үлгэр дууриалал үзүүлж санаачилсан арга хэмжээ | 5 |
| 7. | Санхүүгийн баримт тайланг бүрэн хугацаандаа тайлагнасан байдал | 20 |
| 8. | Тухайн оны гэрээгээр гүйцэтгүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл, тайлагнал | 20 |
| Нийт оноо | | 100 |

Зургаа.ГЭРЭЭ ДҮГНЭХ:

6.1.Биеийн тамир, спортын газрын даргын тушаалаар гэрээ дүгнэх Ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсэг нь сондгой тоотой байх ба тухайн чиглэлийн төрийн бус байгууллагаас 1 төлөөллийг оролцуулна.

6.2.Ажлын хэсэг нь төрийн бус байгууллага, клубуудээс ирүүлсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд үндэслэн шалгуур үзүүлэлт тус бүрээр оноо тавьж, нийлбэр оноогоор дүгнэнэ.

-90-100 оноо “**A буюу бүрэн хангалттай**” үнэлгээ;

-80-90 оноо “**B буюу хангалттай**”;

-70-80 оноо “**C буюу сайжруулах шаардлагатай**”;

-60-70 оноо “**D буюу хангалтгүй**”

6.3.Ажлын хэсэг нь гэрээ байгуулсан төрийн бус байгууллагуудын үнэлгээг талуудад жил бүрийн 12 сарын 10-ны дотор ил тод нээлттэй танилцуулна.

6.4.Биеийн тамир, спортын газар нь ажлын хэсгийн дүгнэлтээр хамгийн өндөр оноо авсан 3 байгууллагыг шалгаруулж тухайн жилийн шилдэг биеийн тамир, спортын байгууллагаар, А үнэлгээг 2 жил дараалан авсан төрийн бус байгууллагыг орон нутгийн шагналд, 3 жил авсан бол улсын шагналд тодорхойлж уламжлах, В үнэлгээ авсан бол гэрээг хэвийн үргэлжлүүлэх, С үнэлгээ авсан бол хязгаарлалттай гэрээ байгуулах, D үнэлгээ авсан бол гэрээ цуцлах шийдвэрийг гаргана.

6.5.Биеийн тамир, спортын газар нь жил бүр хамтран ажиллах гэрээг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.



----оо----